

ТА ХҮҮХДЭЭ ЧЕХ УЛСАД ЕРӨНХИЙ БОЛОВСРО- ЛЫН СУРГУУЛЬД БҮРТГҮҮЛЭХ ГЭЖ БАЙНА УУ?



ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

§§ ЯМАР ҮНДСЭН ЭРХ БА ҮҮРЭГ БАЙДАГ ВЭ? БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ТЭГШ ЭРХ

- Гадаадын иргэдийн хүүхдүүд Чех улсын иргэдийн адил нөхцөлд суурь боловсрол эзэмших эрхтэй. Тэд сургуульд үнэ төлбөргүй боловсрол эзэмших, сургуулийн холны үйлчилгээнд хамрагдах, сургуулийн зохион байгуулж буй дугуйлангуудад хамрагдах эрхтэй.
- Ерөнхий боловсролын сургуульд аль ч орны, ямарч үндэс гаралтай хүүхдүүд мөн бүх төрлийн оршин суух зөвшөөрөлтэй хүүхдүүд хамрагдах эрхтэйгээс гадна бас хууль бусаар оршин сууж байсан тохиолдолд ч хүүхдүүд хамрагдах эрхтэй.

ЧЕХ УЛСАД ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ТУХАЙ ҮҮРЭГ

- Үүрэгт ерөнхий эрдмийн боловсрол нь есөн жил байх ба зургаан наснаас эхлэн суралцана. Үүрэгт боловсрол гэдэг нь ерөнхий суурь боловсролын түвшин бөгөөд хүүхэд энэ үүргийг 17 нас хүртэл гүйцэтгэх ёстой.
- Үүрэгт ерөнхий эрдмийн боловсрол нь мөн ЧУ-ын нутаг дэвсгэрт 90-ээс дээш хоногор оршин сууж буй гадаадын иргэдийн хүүхдүүдэд хамааралтай.
- Хэрэв эцэг эхчүүд нь хүүхдээ сургуульд бүртгүүлээгүй эсвэл сургуульд илгээхгүй байвал хууль зөрчсөнд тооцогдож тухайн асуудлыг Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага нь зөрчил мөн цаашилбал гэмт хэрэгт тооцож хариуцагчдад хариуцлага хүлээлгэнэ.

ХЭРХЭН СУРГУУЛИА СОНГОХ ВЭ?

- Чех улсад ерөнхий боловсролын сургууль нь “улсынх” байдаг. байгуулагч нь сумын, хотын, дүүргийн, аймгийн захиргаа). Эдгээр сургуулиудад хүүхдүүд үнэ төлбөргүй суралцдаг.
- Түүнээс гадна сургууль нь хувийн болон сүмийн байж болох ба эдгээр сургуулиудад сургалтын зардалыг нь төлж суралцана.
- Зарим нэг ерөнхий боловсролын сургуулиуд нь дагнасан сургалттай (хэлний, спортын, тооны г. м) байдаг бөгөөд элсэлтийн шалгалт нь хатуу журамтай байх магадлалтай.

- Ерөнхий боловсролын сургууль нь **бага анги 1. stupeň** **ахлах анги 2. stupeň** гэсэн хоёр шатлалтай. Бага анги нь 5 жил суралцана (нэгдүгээр ангиас тавдугаар анги), ахлах анги нь дөрвөн жил суралцана (зургаадугаар ангиас есдүгээр анги). Ерөнхий боловсролын сургуулийн ахлах шатлалд орогсад олон жилийн гимназид эсвэл дуу хөгжмийн сургуульд мөн суралцаж болно.

ОРОН НУТАГТ ХАРЪАЛАГДАХ СУРГУУЛЬ SPÁDOVÁ ŠKOLA

- Энэ нь хүүхдийн амьдарч буй хаягаас нь шалтгаалан хамаарагдаж буй сургууль юм (хотын болон дүүргийн хуваагдал нь аль сургуульд хамаарагдаж байгааг зохих захиргаанаас лавлаж асууна).
- Орон нутагт харъяалагдаж буй сургуулийн захирал нь оршиж буй орон нутгийнхаа хүүхдүүдийг нэн тэргүүнд авах ёстой.

СУРГУУЛИА ӨӨРСДӨӨ СОНГОХ

- Эцэг эхчүүд нь хүүхэддээ орон нутагт харъяалагдаж буй сургуулиас өөр сургууль сонгож болно. Сургуулиа сонгохдоо тус сургууль нь гэрт эсвэл ажлын газартай ойрхон эсвэл эсвэл тусгай сургалттай, нэр хүндтэй, чанартай мөн сургууль дээр зохиогдож буй гадаад хүүхдүүдэд зориулсан чех хэлний курс гэх мэтийг харгалзан сонгож болох юм.
- Орон нутагт харъяалагдах сургуулиас өөр сургуульд ороход орон тоо дүүрсэн улмаас авахыг татгалзаж болох юм. Дагнан сургалттай сургуульд хүүхэд тань ороход урьдчилан тогтсон нөхцөлийг бүрдүүлэх эсвэл элсэлтийн шалгалтыг амжилттай давсан байх ёстой.



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БҮРТГЭЛ ZÁPIS

ЕБД СУРГУУЛИЙН 1 ДҮГЭЭР АНГИЙН БҮРТГЭЛ ХЭРХЭН ЯВАГДДАГ ВЭ?

- ЕБДС-ийн 1 дүгээр ангийн албан ёсны бүртгэл ихэвчлэн 4-р сард явагддаг ба эдгээр хүүхдүүд нь 8 сарын 31 хүртэлх хугацаанд 6 нас хүрсэн байх ёстой. Бүртгэлийн хугацаа болон тодорхой хангах нөхцөлийг сургуулийн сайтаас эсвэл дүүргийн, хотын сайтаас олж авна уу.
- Эцэг эх нь хүүхдүүдтэйгээ бүртгэлд тогтсон өдөр ба цагт ирж зохих анкетыг бөглөх бөгөөд багш нар тэд бүхэнтэй ярилцлага хийж мөн хүүхдүүдэд хийж чадах хялбар даалгавар өгөх нь элбэг байдаг.
- Бүртгэлийн гол зорилго нь хүүхдийн сургуульд явж чадах бэлтгэлийг хангасаныг тогтоох явдал юм (ярианы чадвар, нийгэмшүүлэлт, зурах бичих чадвар). Сургуульд элсээгүй хүүхдийн эцэг эхчүүдэд бүртгэл явагдсанаас хойш 30 хоногийн дотор захиагаар мэдээлнэ. Сургуульд элссэн хүүхдүүдийн нэрсийн жагсаалт сургуулийн сайт дээр эсвэл сургуулийн хаалганд бүртгэлийн дугаартай нь бичсэн байна.
- Хүүхдийн нас биеийн хөгжил нь 1 дүгээр ангид орж болох түвшинд гүйцээгүй гэж үзэж байгаа тохиолдолд эцэг эх нь **сургуульд орох хугацааг хойшлуулах odklad školní docházky** талаарх хүсэлтийг 5 сарын 31-ний дотор гаргаж болох бөгөөд үүний тулд сургуулиас өгөх маягтыг бөглөнө.
- Сургуульд орох хугацааг хойшлуулахыг Сурган хүмүүжүүлэх-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх газар + мэргэжлийн эмч эсвэл эмнэлэгийн сэтгэл зүйн эмчийн зөвлөмжөөр хийх бөгөөд мөн түүнийгээ бичгээр илэрхийлсэн байх ёстой.

- Сургуульд орох хугацаа нь зөвхөн хүүхдийг 8 нас хүртэл хойшлогдож болдог. Хүүхдийн орох хугацаа нь хойшлогдсон ч гэсэн сургуулийн бүртгэлд хэвээр үлдэнэ.
- Сургуульд орох нь хойшлогдсон хүүхэд **бэлтгэл ангид** **přípravná třída** явж болно. Үүнийг хүүхдийн эцэг эхээс гаргасан өргөдөл ба сургуулийн зөвөлгөө өгдөг мэргэжилтэнээс бичгээр илэрхийлсэн дүгнэлтийг үндэслэж сургуулийн захирал шийдэнэ. Бэлтгэл анги нь хүүхдийн хөгжилийг дэмжиж түүнд сургуульд явах бэлтгэл болно. Бэлтгэл ангийг ихэвчлэн хот ба аймгийн захиргаа байгуулдаг. Хүүхдүүд өдөр өнжүүлэхэд (**školní družina**) явж болно. Харин бэлтгэл ангид явсан жилийг сургуулийн зайлшгүй явах жилд тооцохгүй.

АХЛАХ АНГИЙН ХҮҮХДИЙГ ЭСВЭЛ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ДУНДУУР ХҮҮХЭД ЭЭ ХЭРХЭН БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

- Эцэг эх нь хүүхдээ 1 дүгээр ангиас бусад ангид хичээлийн жилийн хэдийд ч бүртгүүлж оруулж болно.
- Хүүхдээ сургуульд бүртгүүлэхдээ сургуулийн захиралтай биечлэн уулзаж бичгээр бүртгэлийн өргөдөл гаргахыг зөвлөж байна. **ЕБДС-д орох өргөдөл, бүртгэлийн хуудас** **přihláška k základnímu vzdělání a zápisní list**. Танай хүүхдийг сургуульд аваагүй тохиолдолд та давж заалдаж болно. Давж заалдалтыг дээрхи шийдвэр гаргасан захиралд өгөх (бичгээр) ёстой. Сургуулийн захирал нь даван заалдалтыг бүс нутгийн эрх бүхий удирдлагын байгууллага руу илгээх ба тэдгээр нь танай хүүхдийг сургуульд оруулахад нь тусалдаг.
- Чех хэлний мэдлэггүй эсвэл маш муу мэдлэгтэй гэсэн шалтгаанаар хүүхдийг тухайн сургуульд авахгүй байж болохгүй!



ЕБДС-ИЙН БҮРТГЭЛД ЯМАР БАРИМТ БИЧИГҮҮД ШААРДАГДАХ ВЭ?

- Хүүхдийн бичиг баримт (гэрчилгээ, паспорт). Сургууль нь эдгээр бичиг баримтыг зөвхөн хүүхдийн биеийн байцаалтыг нотлох үүднээс хэрэглэдэг ба дээрхи баримтыг хүүхдийн оршин суух зөвшөөрлийг шалгах, визний хүчинтэй хугацаа болон визний төрлийг шалгах үүднээс хэрэглэх эрх байхгүй юм. ЕБС-д бичиг баримтгүй хүүхдүүд ч суралцах эрхтэй.
- Эцэг эхийн бичиг баримт (паспорт эсвэл иргэний үнэмлэх). Сургууль нь эдгээр бичиг баримтыг хүүхдийн хуулийн хариуцагчийн биеийн байцаалтыг нотлох үүднээс хэрэглэх ба дээрхи баримтыг хуулийн хариуцагчийн оршин суух зөвшөөрлийг шалгах, визний хүчинтэй хугацаа болон визний төрлийг шалгах үүднээс хэрэглэх эрх байхгүй юм.
- Хүүхдийн гэрийн хаягыг батлах баримт (жишээ нь байрны гэрээ). Сургууль энэ баримтаас хүүхэд тухай орон нутгийн сургуульд хамаарагдах эсэхийг харна.
- **Гэрчилгээ** **vysvědčení** болон бусад боловсролыг нотлох баримт. Хэрэв хүүхэд өөр гадаад оронд сургуульд сурч байсан тохиолдолд тэр сургуулиас нь нотлох баримт эсвэл гэрчилгээ авчрах юм.
- **Эрүүл мэндийн даатгалын карт** **kartička zdravotního pojištění**. Сургууль энэ мэдээллийг хүсэх боловч хэрэв гадаад хүүхэд нь картгүй эсвэл эрүүл мэндийн даатгалгүй байсан ч энэ нь хүүхдийг сургуульд авахгүй байх шалтгаан нь байж болохгүй.

ХҮҮХЭД ЕБС-Д ОРСОНЫ ДАРАА ЮУ ДАРААЛАХ ВЭ?

- 1 дүгээр ангиас дээш ангид орж буй хүүхдүүдийг сургууль нь, хүүхдийн урд нь явж байсан сургуулийн баримт, гэрчилгээ эсвэл хүүхдийн мэдлэгийн хүрээг харгалзан үзсэний үндсэн дээр түүнийг зохих ангид нь **оруулах ба насыг нь харгалзан үзэж нэг жил улируулж оруулах нь хамгийн тохиромжтой гэж үздэг.**
- Хүүхэд нэг ангид орж суралцаад цаашдаа тэр ангитайгаа дараахь жилүүддээ үргэжлүүлэн суралцдаг.
- Өөр хэлээр ярьдаг хүүхдүүд 1-3 р **нөхөн тэнцүүлэх төлөвлөгөөнд podpůrná opatření** хамаарагдах эрхтэй. Энэ арга хэмжээ нь сурагч бүрийн чех хэлний мэдлэгийн төвшнөөс хамаарна. 2. ба 3. дахь шатны нөхөн тэнцүүлэх төлөвлөгөөнд хамааруулахад сурган хүмүүжүүлэх - сэтгэл зүйн зөвлөгчөөс дүгнэсэн байх шаардлагатай. Нөхөн тэнцүүлэх төлөвлөгөө нь жишээ нь : илүү цагаар ажиллах, толь бичиг, тусгай сурах ном, хичээлийн хэргэсэлээр хангах ба өөрөөр дүн тавих, чех хэлний нэмэлт хичээл хийх ба туслах багш гаргаж өгнө.
- Хүүхдийнхээ ямар хичээлд давамгайл эсвэл дуртай, юугаар ангиа эсвэл сургуулиа төлөөлж байсан (шинжлэх ухаан, спорт, урлаг болон бусад ур чадвар, авьяас) гэх мэтийг сургуульдаа мэдээлээрэй.
- Сургууль нь эцэг эхчүүдийг хүүхдийн ирцийн талаар болон сургуультай холбоотой чухал өөрчлөлтүүдийн талаар мэдээлэх ёстой бөгөөд эдгээр өөрчлөлтүүдийг эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр хийж болохгүй юм (Жишээ нь: Сурган хүмүүжүүлэх-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх газарт үзүүлэх, өөр сургууль руу шилжүүлэх гэх мэт).

ЕБДС хайхад тусламж хэрэгтэй байна уу? Хүүхдээ Чех сургуульд бүртгүүлэхтэй холбоотой илүү мэдээлэл хэрэгтэй байна уу? Хүүхэдээ сургуульд бүртгүүлэхэд тань ямар нэг проблем гарав уу? Сургууль таны хүүхдийг сургуульд авахдаа эрх бус шаардлагыг тавьж байна уу? Та Интэграчлалын төвийн (CIC) нийгмийн ажилтангуудад хандана уу:

CIC Praha: Pernerova 10/32, Praha 8. Утас.: 704 600 700

CIC Kolín: Zahradní 46, Kolín. Утас.: 774 866 838

CIC Mladá Boleslav: Dukelská 1093, Mladá Boleslav. Утас.: 731 512 726

CIC Kladno: Severní 2952, Kladno. Утас.: 735 173 719

CIC Hořovice: Palackého náměstí 640/34 (Хотын захиргааны 3 давхарт), Hořovice.
Утас.: 605 215 649

CIC Mělník: Náměstí Míru 51, Mělník, (Хотын захиргааны 3 давхарт). Утас.: 777 402 129

CIC Liberec: Moskevská 27/14, Liberec. Утас.: 735 752 467

info@cicops.cz

www.cicops.cz



Evropská unie
Evropský sociální fond
Operační program Zaměstnanost

